



## БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БНА-2021/158/СТА/ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2021 он

Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: [tseenyma@audit.gov.mn](mailto:tseenyma@audit.gov.mn)

Аудитор: Н.Бүнчинсүрэн

Утас: 99049866 Цахим хаяг: [bunchinsuren@audit.gov.mn](mailto:bunchinsuren@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	5
2.1.Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
<b>2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан</b> .....	6
2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтын тайлан.....	12
3.Аудитын тайлан .....	13
3.1. Ерөнхий зүйл .....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	13
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.9. Аудитын илрүүлэлт .....	17
Залруулсан алдаа.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	18
Аудитын зөвлөмж.....	19
3.9. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	19
4. Менежментийн захидал.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	20



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН  
СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА М.ХОСБАЯР  
ТАНАА

2021.02.01 № 2/08

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г \_\_\_\_\_ 7

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа

2021 А4 ТООТ

005020842



нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Б.МӨНХБАТ



## Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

### 2.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөг/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,425,545.70	32,174,370.90
33	АВЛАГА	2,711,798.55	14,641,173.62
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	10,782.52
335	Бусад авлага	2,711,798.55	14,630,391.10
3351	Байгууллагаас авах авлага	2,711,798.55	14,630,391.10
35	БАРАА МАТЕРИАЛ	13,713,747.15	17,533,197.28
351	Түүхий эд материал	6,136,751.00	6,676,979.55
35110	Тусгай зориулалттай материал	47,000.00	12,000.00
35130	Эм боох материал	6,089,751.00	6,664,979.55
354	Хангамжийн материал	7,576,996.15	10,856,217.73
35410	Бичиг хэргийн материал	1,266,500.00	2,520,000.00
35420	Аж ахуйн материал	6,310,495.73	8,336,217.73
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	173,404,384.27	171,366,502.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	173,404,384.27	171,366,502.54
392	Биет хөрөнгө	137,700,384.27	135,728,502.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	127,029,515.90	127,029,515.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,762,897.30	-10,411,106.70
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,484,404.20	21,738,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21,785,771.59	-16,608,164.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,185,241.22	19,140,376.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,950,108.16	-8,427,185.74
39209	Зам, гүүрийн байгууламж	3,500,000.00	3,500,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-233,333.28
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,810,000.00	4,810,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,810,000.00	-4,810,000.00
393	Биет бус хөрөнгө	35,704,000.00	35,638,000.00
39301	Програм хангамж	896,000.00	896,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-742,000.00	-808,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	35,550,000.00	35,550,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	189,829,929.97	203,540,873.44
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	189,805,009.51	203,540,873.44
51	Засгийн газрын хувь оролцоо	189,805,009.51	203,540,873.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	96,568,996.01	96,568,996.01
51101	Өмч: - төрийн	96,568,996.01	96,568,996.01
512	Хуримтлагдсан үр дүн	36,137,927.51	52,859,073.74
51210	Өмнөх үеийн үр дүн	36,137,927.51	39,123,209.81
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	13,735,863.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,098,085.99	54,112,803.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	189,829,929.97	203,540,873.44

## 2.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	279,129,133.00	423,678,784.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,678,257.00	269,226,673.00
120	Нийтлэг татварын бус орлого	66,678,257.00	269,226,673.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	64,478,257.00	269,226,673.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,478,257.00	268,266,273.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	960,400.00
120005	Түрээсийн орлого	2,200,000.00	00.00
120009	Бусад орлого	00.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	212,450,876.00	154,452,111.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	180,193,800.00	132,587,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	180,193,800.00	132,587,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,257,076.00	21,864,411.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,257,076.00	2,150,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	14,714,411.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	265,699,083.09	409,942,920.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	265,699,083.09	409,942,920.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	200,720,538.64	233,518,231.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	129,243,066.00	148,557,174.11
210101	Үндсэн цалин	129,243,066.00	148,557,174.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,346,512.66	18,442,255.53
210201	Тэтгэврийн даатгал	11,187,115.92	12,679,821.53
210202	Тэтгэмжийн даатгал	1,366,706.74	1,485,572.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,018,154.00	1,188,454.00
210204	Ажилгүйдлийн даатгал	252,231.00	280,764.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,522,305.00	2,807,644.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,066,766.90	17,332,905.27
210301	Гэрэл, цахилгаан	6,586,706.90	6,233,125.27
210302	Түлш, халаалт	6,554,240.00	8,365,500.00
210303	Цэвэр, бохир ус	2,925,820.00	2,734,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,778,265.10	11,729,722.06
210401	Бичиг хэрэг	3,321,210.00	2,687,770.00
210402	Тээвэр, шатахуун	3,658,832.63	3,002,779.96
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	798,649.77	1,379,994.10

**Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	672,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,999,572.70	3,987,178.00
2105	Нормативт зардал	9,526,142.00	15,782,586.45
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,326,142.00	15,782,586.45
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	262,100.00	2,134,006.00
210604	Урсгал засвар	262,100.00	2,134,006.00
2107	Томилолт, зочны зардал	6,549,750.00	4,313,000.00
210702	Дотоод албан томилолт	6,549,750.00	4,313,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,513,120.00	6,568,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,071,660.00	6,124,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
210807	Газрын төлбөр	11,000.00	142,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	42,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	270,460.00	100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,434,815.98	8,658,381.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,537,000.00	334,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	286,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,897,815.98	8,037,881.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,978,544.45	176,424,688.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	499,950.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	499,950.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	64,478,594.45	176,424,688.92
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	47,553,740.92
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	64,478,257.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	337.45	128,870,948.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,430,049.91	13,735,863.93
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	13,430,049.91	13,735,863.93

### 2.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	277,004,777.00	425,419,359.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,478,257.00	268,266,273.00
120	Нийтлэг татварын бус орлого	64,478,257.00	268,266,273.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	64,478,257.00	268,266,273.00

**Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,478,257.00	268,266,273.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
120005	Түрээсийн орлого	00.00	00.00
120009	Бусад орлого	00.00	00.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>212,526,520.00</b>	<b>157,153,086.10</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	180,193,800.00	132,587,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	180,193,800.00	132,587,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,332,720.00	24,565,386.10
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	2,700,975.10
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,332,720.00	2,150,000.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	14,714,411.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>263,893,817.00</b>	<b>419,419,359.10</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>263,893,817.00</b>	<b>419,419,359.10</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>196,214,297.45</b>	<b>232,966,248.18</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	129,397,558.93	143,720,834.98
210101	Үндсэн цалин	88,248,958.93	105,239,050.07
210102	Нэмэгдэл	35,449,300.00	34,177,534.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,699,300.00	4,131,000.00
210104	Урамшуулал	00.00	173,250.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,174,762.12	19,333,679.73
210201	Тэтгэврийн даатгал	10,999,062.12	13,402,987.17
210202	Тэтгэмжийн даатгал	1,186,100.00	1,445,423.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,056,600.00	1,393,906.99
210204	Ажилгүйдлийн даатгал	345,000.00	281,311.43
210205	Эрүүл мэндийн даатгал	2,588,000.00	2,810,050.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,790,730.00	17,332,905.27
210301	Гэрэл, цахилгаан	4,310,670.00	6,233,125.27
210302	Түлш, халаалт	7,589,120.00	8,365,500.00
210303	Цэвэр, бохир ус	1,890,940.00	2,734,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,597,601.50	7,679,694.10
210401	Бичиг хэрэг	995,060.00	1,600,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,027,469.00	3,027,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	898,399.77	1,379,994.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	672,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	676,672.73	1,000,000.00
2105	Нормативт зардал	7,725,000.00	17,000,000.00

**Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,725,000.00	15,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,851,040.00	4,800,000.00
210602	Тавилга	302,940.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	420,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	1,128,100.00	4,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,666,700.00	4,313,000.00
210702	Дотоод албан томилолт	3,666,700.00	4,313,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,660,904.90	15,786,134.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,844,744.90	14,841,964.10
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
210807	Газрын төлбөр	11,000.00	142,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	42,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	645,160.00	599,970.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,350,000.00	3,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,300,000.00	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,679,519.55	186,453,110.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	499,950.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	499,950.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	67,179,569.55	186,453,110.92
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	64,478,257.00	57,582,162.92
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,701,312.55	128,870,948.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	13,110,960.00	6,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,110,960.00	6,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,110,960.00	6,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,110,960.00	6,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,110,960.00	6,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-13,110,960.00	-6,000,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

## 2.4 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,568,996.01	57,098,085.99	22,707,877.60	176,374,959.60
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,568,996.01	57,098,085.99	22,707,877.60	176,374,959.60
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,568,996.01	57,098,085.99	36,137,927.51	189,805,009.51
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,568,996.01	57,098,085.99	36,137,927.51	189,805,009.51
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,985,282.30	2,985,282.30
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,568,996.01	57,098,085.99	39,123,209.81	192,790,291.81
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-2,985,282.30	00.00	-2,985,282.30
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,568,996.01	54,112,803.69	52,859,073.74	203,540,873.44

## 2.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	233,587,700.00	224,429,284.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	233,587,700.00	224,429,284.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	227,708,600.00	224,429,284.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143,721,800.00	143,720,834.98
210101	Үндсэн цалин	103,695,600.00	105,239,050.07
210102	Нэмэгдэл	35,868,200.00	34,177,534.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,158,000.00	4,131,000.00
210104	Урамшуулал	00.00	173,250.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,402,400.00	19,333,679.73
210201	Тэтгэврийн даатгал	13,653,600.00	13,402,987.17
210202	Тэтгэмжийн даатгал	1,437,200.00	1,445,423.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,149,800.00	1,393,906.99
210204	Ажилгүйдлийн даатгал	287,400.00	281,311.43

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЭТ

Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	2,874,400.00	2,810,050.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	17,611,500.00	17,332,905.27
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	6,233,125.27
210302	Түлш, халаалт	10,468,500.00	8,365,500.00
210303	Цэвэр, бохир ус	4,143,000.00	2,734,280.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,679,700.00	7,679,694.10
210401	Бичиг хэрэг	1,600,000.00	1,600,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,027,700.00	3,027,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,380,000.00	1,379,994.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	672,000.00	672,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	17,000,000.00	17,000,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	2,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,800,000.00	10,800,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	6,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	4,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,000,000.00	4,313,000.00
210702	Дотоод албан томилолт	7,000,000.00	4,313,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,493,200.00	1,249,170.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	305,000.00	305,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	160,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	125,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	83,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	28,000.00	00.00
210807	Газрын төлбөр	142,200.00	142,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	42,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	600,000.00	599,970.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3000000.00	3000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5879100.00	0.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,879,100.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,229,100.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	650,000.00	00.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	233,282,700.00	224,429,284.08
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	132,282,700.00	123,429,284.08
131001	Улсын төсвөөс санхүүжих	132,282,700.00	123,429,284.08



Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	101,000,000.00	101,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	101,000,000.00	101,000,000.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	13	13
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	1	1
620004	Гэрээт ажилтан	2	2
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>13</b>	<b>13</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	4	4
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8
650010	Гэрээт ажилтан	1	1

**2.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтын тайлан**

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,531,744.90	14,536,964.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,531,744.90	14,536,964.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,531,744.90	14,536,964.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,531,744.90	14,536,964.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,531,744.90	14,536,964.10
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,531,744.90	14,536,964.10
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,531,744.90	14,536,964.10
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,822,184.90	2,700,975.10
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,709,560.00	645,000.00
131106	Төсвийн урамшуулал		6,190,989.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-



### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг хэлтсийн дарга М.Хосбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 сарын 27-ноос 2021 оны 01 сарын 29-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.11.05-ны өдрийн 117 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн 2020 оныг "Өөрчлөлт шинэчлэлтийн жил" болгон зарласантай холбогдуулан дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Хэмжил зүйн тухай хуулийн дагуу хэмжих хэрэгслүүдийг улсын баталгаажуулалтад бүрэн хамруулж, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг хэмжих хэрэгсэлд итгэх итгэлийг нэмэгдүүлж, төрийн хяналт шалгалтыг хуулийн хүрээнд явуулах.
- Аймаг орон нутагт стандартын шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний тоог нэмэгдүүлж, зах зээлийн шаардлагад нийцсэн экспортын чиг баримжаатай, импортыг орлог бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх.
- Стандартын байгууллага ба аж ахуйн нэгжийн уялдаан сайжруулах, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлж стандартын тухай ойлголтыг нэмэгдүүлэх.
- Үнэт металлын сорьц тогтоох лабораторийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэн, өргөжүүлэх.

#### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.



Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Монгол улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газар нь 2020 онд харьяа орон нутаг дахь Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны 3 дугаар улирлын нийт зардлын 167,192.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 3343.8 мянга, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 409942,9 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 8198.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 203540,8 мянга өмнөх оноос 13710.9 мянган төгрөгөөр буюу 7.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	16,425.5	32,174.4	15,748.8
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	2,711.8	14,641.2	11,929.4
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	13,713.7	17,533.2	3,819.5
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	173,404.4	171,366.5	(2,037.9)
Үндсэн хөрөнгө	215,455.2	212,664.3	(2,790.9)
Хуримтлагдсан элэгдэл	(42,050.8)	(41,297.8)	753.0
Нийт хөрөнгө	189,829.9	203,540.9	13,710.9
Өр төлбөр	24.9	-	(24.9)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	189,805.0	203,540.9	13,735.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	189,829.9	203,540.9	13,710.9

Авлага дансны үлдэгдэл 14641.2 мянган төгрөг болж 11929.4 мянган төгрөгөөр өссөн нь НДШ-ийн авлага 10.8 мянга, нэмэлт санхүүжилтийн дансанд давсан орлогын урамшуулалд 14714.4 мянган төгрөг СХЗГ-аас хуваарилгасныг чек алт авах зориулалттай 8523,4 мянга, түрээсийн орлого 1494.2 мянган төгрөгийг зарцуулаагүй Сангийн яам руу төвлөрүүлсэн, мөн автограшийн барилга бариулахаар 4601.9 мянган төгрөгийг “Би Эйч Энд Ди” ХХК руу гэрээ хийж 2020.12.22-нд шилжүүлснийг авлагаар тайлагнасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 17533.2 мянган төгрөг болж 3819.5 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материалын үлдэгдэл 1253.5 мянга, аж ахуйн материал 2025.7 мянга, эм боох материал 575.2 мянган төгрөг болж өссөнтэй холбоотой байна.

Энэ нь бичиг хэргийн зардал Стандарт, хэмжил зүйн газраас 960.4 мянган төгрөгийн үнэт цаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн, аж ахуйн материал 2000.0 мянган төгрөгийн албан хаагчдын дүрэмт хувцас авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 212664.3 мянган төгрөг болж 2790.9 мянган төгрөгөөр буурсан нь урсгал төсвийн худалдан авалтаар тавилга хэрэгсэл 6000.0 мянга, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2020.11.03-ны өдрийн А/1921 тоот албан бичгээр 8790.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл акталсныг данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 203540.9 мянган төгрөг болж 13735.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 13735.9 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 423678.8 мянган төгрөг болж өмнөх оноос 144549.6 мянган төгрөгөөр буюу 51.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 144549.6 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь үндсэн үйл ажиллагааны орлого 204188.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ. Үндсэн үйл ажиллагааны орлого өссөн нь баталгаажуулалтын үйлчилгээний орлого өссөн, цар тахал гарсантай холбоотой орон нутагт үнэт металлын сорьц тогтоох үйлчилгээ, шинжилгээ хийх ажил орон нутагт бүрэн хийгдэж байгаатай холбоотой байна.

Нийт зардал 409942.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 144243.8 мянган төгрөгөөр буюу 54.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд байна. Энэ нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, шуудан холбоо интернэтийн төлбөр, бага үнэтэй түргэн элэгдэл зүйл, эм, урсгал засварын зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 233587.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 233587.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хэргүүлснийг баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 233587.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 132587.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 101000.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.



Гүйцэтгэлээр улсын төсвөөс 233587.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 268266.3 мянган төгрөгийг оруулж, нийт 501854.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 224429.3 мянган төгрөгийг зарцуулж, 277424.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 224429.3 мянган төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь дотоод албан томилолтын зардал 2687.0 мянга, тэтгэвэрт гарах нэг удаагийн мөнгөн тэтгэмж 5229.1 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 650.0 мянга, даатгалын үйлчилгээ 125.0 мянга, тээврийн хэрэгслийн татвар 83.0 мянга, тээврийн хэрэгслийн оношилгоо 28.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээ 9158.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Энэ нь цар тахалтай холбоотой албан томилолтын зардал, тээврийн хэрэгсэл байхгүй тул даатгалын үйлчилгээ, тээврийн хэрэгслийн татвар, оношилгооны зардал, сангийн яамнаас зарцуулах эрхийг нь нээж өгөхгүй байсны улмаас үйлчлэгч ажилтай Л.Одгэрэлийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардал болон нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал тус тус хэмнэлт үүссэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд 101000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 268266.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 165.6 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	101000.0	268266.3	167266.3	165.6
<b>Нийт дүн</b>	101000.0	268266.3	167266.3	165.6

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Түрээсийн орлого 2150.0 мянга, орон нутгийн ангилагдаагүй зардлаас төрийн албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэхэд 5000.0 мянга, урд оны авлага 2700.9 мянга, Стандарт, хэмжил зүйн үндэсний төвөөс давсан орлогын урамшуулал 14714.4 нийт 24565.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс төрийн албан хаагчдад орон сууцны дэмжлэг 1 албан хаагчдад 5000.0 мянга, урд оны авлагаас 2700.9 мянга, давсан орлогын урамшууллаас 6191.0 мянга, түрээсийн орлогын 30 хувь 645.0 мянган төгрөгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар шилжүүлж, нийт 14536.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 10028.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 1, байршуулаагүй 5 мэдээлэл байна.

Цалингийн сангаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ байршуулсан эсэхийг хянаж үзэхэд орлогын 10 гүйлгээний 143061.1 мянга, зарлагын 8 гүйлгээний 222906.0 мянган төгрөгийг байршуулж, төрийн албан хаагчдад олгох орон сууцны дэмжлэг үзүүлэхэд 5000.0 мянган төгрөгийн орлого, зарлагын мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	5		4	2
2	Хагас жил	4	4	4			
3	Улирал бүр	1	4	3		1	
4	Сар бүр	3	36	36			
5	Тухай бүр	8	96	95	1		
6	Нийт	27	151	143	1	5	2

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 28671.4 мянган төгрөгийн зөрчилд 1744.7 мянган төгрөгийг санхүүгийн тайланд залруулж, 26926.7 мянган төгрөгийн зөрчилд зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Аудитаар өгсөн 26926.7 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн даргын 2020.06.19 өдрийн 90 дүгээр албан бичгээр хариуг ирүүлсэн ба биелэлт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	1	26926.7	1	26926.7	0	0	0
Нийт дүн	1	26926.7	1	26926.7	0	0	0

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7667.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4906.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 60.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 2700.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

## **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Урсгал засварын зардлаас автограшийн барилга бариулахаар 2020.12.22-нд "Би эйч энд ди" ХХК руу 4000.0 мянга, нэмэлт санхүүжилтийн данснаас 601.9 мянган нийт 4601.9 мянган төгрөгийг шилжүүлж барилга бариагүй байхад үндсэн хөрөнгөнд орлого авсан нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 14 дүгээр зүйл 14.4 Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. 14.4.2 "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.27 "Урьдчилж төлсөн төлбөрийг үүссэн тооцоо буюу төлсөн мөнгөн дүнгээр үнэлж бүртгэнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.  
Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд авлагаар бүртгэж залруулав.
2. Улсын төсвөөс санхүүжих "Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс болох" зориулалттай 305.0 мянган төгрөг харилцах дансанд орсныг нягтлан бодогч дансны бичилт хийхдээ тусгай зориулалтын шилжүүлгийн орлого дансанд бүртгэсэн байна.  
Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд улсын төвлөрсөн төсвийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт дансанд бүртгэж залруулав.

## **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 2760.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 60 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2700.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1.Тээвэр шатахууны зардлаас 2020.12.22-нд албан хаагчдад шатахууны нөхөн олговор болох 60.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүйгээр олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2.Нягтлан бодогч нярвын тайланг сар бүр тооцоог бодож баталгаажуулаагүйгээс нярвын гаргасан тайлан санхүүгийн тайлангийн бараа материалын орлогоос 164.9 мянган төгрөгөөр илүү, зарлага 2535.3 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалт, оршин байх, эрх ба үүргийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх



## **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.9. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Цаашид анхан шатны баримт бүрдэлгүй зардал гаргасан, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх байдлыг тус тус авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл**

###### **1.1 Илрүүлэлт**

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 1, байршуулаагүй 5 мэдээлэл байна. Мөн цалингийн сангаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 10 мөнгөн гүйлгээний 143064.1 мянга, зарлагын 8 мөнгөн гүйлгээний 222906.0 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээ байршуулсан ба төрийн албан хаагчдад олгох орон сууцны дэмжлэг үзүүлэхэд олгосон 5000.0 мянган төгрөгийн орлого зарлагын мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

###### **1.2. Эрсдэл**

Хуульд заасан мэдээллийг байршуулаагүй байх

###### **1.3. Өгсөн зөвлөмж**

Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

###### **1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар**

Хүлээн зөвшөөрсөн

**2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой**

###### **2.1 Илрүүлэлт**

Үндсэн хөрөнгө хүлээж аваагүй байж орлогоор бүртгэсэн, нярвын тайланг хянаж баталгаажуулдаггүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ын 4.15 Бараа материал, 4.30 Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

###### **2.2. Эрсдэл**

Нярвын тайланг хянаагүй, бараа материалын орлого, зарлагыг зөв бүртгээгүй байх.

###### **2.3 Өгсөн зөвлөмж**

Анхан шатны баримтыг үндэслэн гүйлгээ хийж эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж тооллогыг хийж үр дүнг баталгаажуулж байх, нярвын тайланг сар бүр хянаж хүлээн авч баталгаажуулан нягтлан бодогч Сангийн сайдын 388 тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлалыг мөрдөж ажиллах.

###### **2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар**

Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт


Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			БНА-2021/158/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянхонгор аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тээвэр шатахууны зардлаас 2020.12.22-нд албан хаагчдад шатахууны нөхөн олговор болох 60.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүйгээр олгосон байна.	60.0	Төлбөрийн акт тогтоох	Хэлтсийн дарга Нягтлан бодогч	М.Хосбаяр Д.Баярмаа
2	Нягтлан бодогч нярвын тайланг сар бүр тооцоог бодож баталгаажуулаагүйгээс нярвын тайлан санхүүгийн тайлангийн бараа материалын орлогоос 164.9 мянган төгрөгөөр илүү, зарлага 2535.3 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй байна.	2700.2	Албан шаардлага өгөх	Хэлтсийн дарга Нягтлан бодогч	М.Хосбаяр Д.Баярмаа
3	Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 1, байршуулаагүй 5 мэдээлэл байна. Мөн цалингийн сангаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ байршуулсан эсэхийг хянаж үзэхэд төрийн албан хаагчдад олгох орон сууцны дэмжлэг үзүүлэхэд 5000.0 мянган төгрөгийг мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна	0	Зөвлөмж өгөх	Хэлтсийн дарга Нягтлан бодогч	М.Хосбаяр Д.Баярмаа
4	Улсын төсвөөс санхүүжих "Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс болох" зориулалттай 305.0 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр бүртгэсэн байна.	305.0	Санхүүгийн тайланд залруулах	Хэлтсийн дарга Нягтлан бодогч	М.Хосбаяр Д.Баярмаа

5	Урсгал засварын зардлаас автограшийн барилга бариулахаар 2020.12.22-нд "Би эйч энд ди" ХХК руу 4000.0 мянга, нэмэлт санхүүжилтийн данснаас 601.9 мянган нийт 4601.9 мянган төгрөгийг шилжүүлж автограшийн барилга бариагүй байхад үндсэн хөрөнгөнд орлого авсан байна.	4601.9	Санхүүгийн тайланд залруулах	Хэлтсийн дарга Нягтлан бодогч	М.Хосбаяр Д.Баярмаа
6	Үндсэн хөрөнгө хүлээж аваагүй байж орлогоор бүртгэсэн, нярвын тайланг хянаж баталгаажуулдаггүй зэрэг зөрчлүүд илэрлээ.	0	Зөвлөмж өгөх	Хэлтсийн дарга Нягтлан бодогч	М.Хосбаяр Д.Баярмаа
<b>ДҮН</b>		<b>7667.1</b>			

Бэлтгэсэн:

АУДИТОР



Н.БҮНЧИНСҮРЭН  
Огноо: 2021.01.29

Анхан шатанд хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕР



А.ЦЭЭНЯМ  
Огноо: 2021.01.29

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ  
Огноо: 2021.01.29